



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 1/64

Мөрөн сүм

Г Хорио цээрийн дэглэмийг шинэчлэн
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын саналыг үндэслэн Рашиант, Их-уул, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Галт сумуудад малын гоц халдварт бог малын мялзан өвчний тохиолдол бүртгэгдэж, хорио цээрийн дэглэм хэрэгжиж байгаатай холбогдуулан бог малын мялзан өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, бусад сумдад халдварт дамжихаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 02 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн өвчний тохиолдол бүртгэгдсэн дээрх сум, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хорио цээрийн дэглэмийг шинэчлэн тогтоосугай.

2. Хорио цээрийн дэглэм тогтоосон бус нутгаас амьд мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, өвс тэжээлийн тээвэрлэлт, отор, нүүдэл, малын худалдаа, солилцоо, үзэсгэлэн, уралдаан зохион байгуулах болон бусад зориулалтаар малын шилжилт хөдөлгөөн хийхийг хориглосугай.

3. Мал амьтны гоц халдварт Бог малын мялзан өвчинтэй тэмцэх зааврын дагуу уг өвчинтэй тэмцэх, сэргийлэх, тархвар зүй, дэгдэлтийн судалгаа хийх, халдвартай хийхийг хэрэгжүүлэх, дархлаажуулалтын ажлыг шуурхай зохион байгуулах, мэргэжил арга зүй удирдлагаар хангах ажлын явцыг тухай бүр танилцуулж, үр дүнг аймгийн Онцгой комиссын шуурхай штабт тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа)-д, хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлж, бог малын мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж хариу арга хэмжээнд шаардагдах хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодис, тоног төхөөрөмж, шатахуун бусад шаардагдах хэрэглэгдэхүүний нөөц бурдүүлж шуурхай бэлэн байдлыг хангаж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Өвчлөл илэрсэн сум, багийн голомтын бүсээс гадагш гарах малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хяналтын постуудад хүн хүч, техник хэрэгсэл нэмэгдүүлж, гамшгийн үеийн шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ё.Пүрэвсүрэн), малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, хэв журам сахиулж ажиллахыг Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа А.Алтанцож) нарт тус тус даалгасугай.

5. Бог малын мялзан өвчний тархалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор сум, баг хоорондын мал, амьтны шилжилт хөдөлгөөн, отор нүүдэлд хязгаарлалт хийж, эрүүл сум, баг, бус нутгийг халдвараас хамгаалах, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, захирамж зөрчсөн иргэн хуулийн этгээдэд,

2.

хуулийн дагуу арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлж, хариуцлага тооцож ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, цаг үеийн шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

